МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

**ЦЭВЭР ХӨГЖЛИЙН МЕХАНИЗМ БОЛОН ЯПОН МОНГОЛЫН ХАМТАРСАН КРЕДИТ ОЛГОХ МЕХАНИЗМЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ СЕМИНАР**

**2013 оны 4 сарын 26**

# Нүүрстөрөгчийн зах зээл: Ерөнхий танилцуулга

Уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах албаны ЦХМ-ын үндэсний товчооны дарга Б.Цэндсүрэн

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

# Агуулга

1. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар ерөнхий танилцуулга
2. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны санхүүжилт ба Нүүрстөрөгчийн зах зээл түүний механизмууд

# 1. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар ерөнхий танилцуулга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

# Уур амьсгалын өөрчлөлт ба XX-н ялгаралтыг бууруулах хэрэгцээ




Үйл... тий... эх... хой... мандал дахь нүүрсхүчлийн хий 30%-иар өсчээ. Үүний ихэнхи нь шатах ашигт малтмалын шаталтаас болсон байна.

# Уур амьсгалын өөрчлөлт ба ХХ-н ялгаралтыг бууруулах хэрэгцээ

***Хүлэмжийн үзэгдэл***

- ***Хүлэмжийн хий (Greenhouse gas):*** Агаар мандалд өчүүхэн бага хэмжээтэй орших боловч дэлхийн гадаргаас туяарах урт долгионтой гэрлийн цацрагийг шингээж, агаарт нэмэлт дулааныг бий болгох шинж чанартай тодорхой долгионы урт бүхий хийнүүд (усны уур, нүүрсхүчлийн хий, метан, азотын давхар исэл, хлор-фторт нүүрстөрөгч зэрэг)-ийг хүлэмжийн хий гэж нэрлэдэг. Эдгээр хий байх ёстой хэмжээнээсээ илүү ихээр хуримтлагдсанаас дэлхийн уур амьсгал өөрчлөгдөхөд хүрдэг.
- ***Хүлэмжийн үзэгдэл (Greenhouse effect):*** Үүл, зарим төрлийн хийн агаар мандал дахь агууламж нэмэгдсэнээр нарнаас ирж буй богино долгионт цацрагийг дотогш хэвийн нэвтрүүлэх боловч дэлхийн гадаргаас цацарч буй урт долгионт цацрагийг өөртөө шингээж, улмаар агаар мандлын доод давхаргын температур нэмэгдэхэд хүргэх үзэгдлийг хүлэмжийн үзэгдэл гэдэг.



# Уур амьсгалын өөрчлөлт ба ХХ-н ялгаралтыг бууруулах хэрэгцээ

- 1992 оны 04 сарын 03-14 хооронд Бразилийн Рио Де Жанеро хотноо зохион байгуулагдсан “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт НҮБ-ын Бага хурлаар “Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц”-ийг батлан гаргасан.
- НҮБУАӨСК-ийн эцсийн зорилго нь “***Агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг уур амьсгалын системд ноцтой өөрчлөлт оруулахааргүй түвшинд байлгаж тогтворжуулах***” юм.




Эх сурвалж: Analytics/PIK, 2012

**Дэлхийн Дулаарлыг 2°C-аас хэтрүүлэхгүй байх (2009, Копенхаген)**

Конвенцийн талуудын 17-р бага хурлаас ХХ-н ялгаралтыг бууруулах үйл ажиллагааг нэмэгдүүлэх, үр ашигтай бага зардлаар бууруулах боломжийг олгох зорилгоор одоо байгаа зах зээлийн механизмууд дээр нэмэлт байдлаар шинэ арга хэрэгсэл, механизмыг бий болгон хэрэгжүүлэх талаар тохирсон

# 2.Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны санхүүжилт ба Нүүрстөрөгчийн зах зээл түүний механизмууд

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

# Уур амьсгалын өөрчлөлтийн санхүүжилт




Эх сурвалж: The landscape of climate finance 2012

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

# Нүүрстөрөгчийн зах зээл

## Хүлэмжийн хийн ялгаралтын бууралтын худалдаа




## Хүлэмжийн хийн ялгаруулах эрхийн худалдаа




## Нүүрстөрөгчийн зах зээл гэж юу вэ?

Хүлэмжийн хийн ялгаралтын бууралтын худалдаа хэрхэн явагддаг вэ? Яаж нүдэнд үзэгдэхгүй гарт баригдахгүй хийг зах зээл дээр худалдаалагдах бараа, бүтээгдэхүүн болгон хувиргадаг вэ?

**а/**Хүлэмжийн хийнүүдийг тодорхойлох **б/**Тэдгээр хүлэмжийн хийг хооронд нь харьцуулах үүднээс нэг хэмжигдэхүүнээр илэрхийлэх

**в/**Зах зээл дээр худалдаалагдах стандарт барааг бий болгох

# Хүлэмжийн хийнүүд

| **Нэр** | **Химийн томьёо** | **Дэлхийн дулаарлын чадамж** |
|---|---|---|
| CO2 | $CO_2$ | 1 |
| Метан | $CH_4$ | 21 |
| Азотын исэл | $N_2O$ | 310 |
| Перфторт нүүрстөрөгчийн нэгдлүүд | $C_2F_6$ | 9200 |
| | $C_5F_{12}$ | 7500 |
| | $C_6F_{14}$ | 7400 |
| Гексафторт нүүрстөрөгч | $SF_6$ | 23900 |
| Усфторт нүүрстөрөгчийн нэгдлүүд | $CHF_3$ | 11700 |
| | $C_3H_2F_6$ | 6300 |
| | $C_2H_3F_3$ | 3800 |
| | $CH_2FCF_3$ | 1300 |
| | $C_2H_2F_4$ | 1000 |
| | $CH_2F_2$ | 650 |
| | $CH_3F$ | 150 |

# Зах зээлийн төрөл

**Зах зээл**

- **Зайлшгүй дагаж мөрдөх** — Конвенц, Киотогийн протоколын хүрээнд бий болсон механизмууд
  - **Уян хатан механизмууд**
    - Цэвэр хөгжлийн механизм
    - Хамтарсан хэрэгжүүлэлт
    - Олон улсын ялгаралтын худалдаа
    - Хоёр талын болон бусад механизмууд
  - **Ялгаруулах эрхийн худалдаа**
    - ЕХЯХТ
    - Орон нутгийн тогтолцоонууд UK-ETS, NZ, AUS, CAN
    - Бусийн – RGGI, NSW
- **Сайн дурын**
  - Байгууллагууд
  - Хувь хүмүүс

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

# Зах зээлийн төрөл

| Зах зээлийн төрөл | Бүтээгдэхүүний төрөл, хэлбэр | | Механизмууд |
|---|---|---|---|
| Зайлшгүй дагаж мөрдөх | Эрхийн гэрчилгээ | AAU (Assigned Amount Units) | Олон улсын ялгаралтын худалдаа |
| | | EUA (EU Allowance) | ЕХЯХТ |
| | Төсөлд суурилсан ялгаралтын бууралтын гэрчилгээ | ERU (Emission Reduction Unit) | Хамтарсан хэрэгжүүлэлт |
| | | CER (Certified Emission Reduction) | Цэвэр хөгжлийн механизм |
| Сайн дурын | Голчлон төсөлд суурилсан ялгаралтын бууралтын гэрчилгээ | VER (Verified Emission Reduction) | Сайн дурын төслүүд |

# Нүүрстөрөгчийн зах зээл, нүүрстөрөгчийн худалдаа гэж юж вэ?

1. Хүлэмжийн хийн ялгаралтын бууралтын кредитүүд болон хүлэмжийн хийн ялгаралтын эрхүүд худалдаалагддаг зах зээл юм.
2. **Зах зээлийн эрэлтийг** олон улсын, үндэсний, бүсийн болон орон нутгийн бодлого, хууль, дүрэм, журмаар бий болгож байдаг.
3. Хүлэмжийн хийн ялгаралтын бууралт болон шингээлтийг хэмжих, тайлагнах, нотлох талаар маш нарийн **техник , стандарт зохицуулалт** дээр суурилдаг.
4. Цэвэр, нүүрстөрөгч багатай хөгжлийн **хөшүүрэг** болж тогтвортой хөгжлийг дэмжих нэг механизм болдог.




Эх сурвалж: Нүүрстөрөгчийн зах зээлийн өнөөгийн байдал , цаашдын хандлага 2012

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

# Анхаарал тавьсанд баярлалаа!

www.mne.gov.mn

www.climatechange.gov.mn

www.cdm-mongolia.com